



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/12

Алтрага

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, 4.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын 2023 оны А/600 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бодит нөхцөл байдлыг тогтоож, отроор явсан, ирсэн өрхийн судалгааг гаргах, малчдад эрүүл мэнд, нийгэм, төрийн үйлчилгээг үзүүлэх ажлыг зохион байгуулах ажлын 500,000 (таван зуун мянга) төгрөгийг тээвэр шатахуун болон бусад хангамжийн материалд зарцуулсугай.

2. Дээрх зардлын 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргаж зарцуулахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга), нягтлан бодогч (Э.Ариунаа)-нарт зөвшөөрсүгэй.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010328